



АЛБАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААР

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын eDoc программд 2021 оны 01 дүгээр сарын 01-нээс 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 2635 албан бичиг ирсэн байна. Үүнээс Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр 9, хэвлэмэл хэлбэрээр ирж байгууллагаар 375, eDoc системээр 2251 албан бичиг тус тус бүртгэгдсэн байна.

Хариутай ирсэн албан бичгийн шийдвэрлэлтийг графикаар харуулбал:



Хариугүй ирсэн албан бичгийн шийдвэрлэлтийг графикаар харуулбал:



Edoc системээр болон хэвлэмэл байдлаар ирсэн албан бичгийн бүрдлийн шаардлага хангагдахуйц байдалд хяналт тавин, шаардлага хангаагүй албан бичгийг буцааж ахин ирүүлэх арга хэмжээг авч ажилласан. Мөн хүлээлгэн өгсөн хүний гарын үсгээр баталгаажуулан ирсэн баримт бичгийн бүртгэлд тэмдэглэж цаг тухай бүрт нь Edoc системд бүртгэж байсан болно.

Шийдвэрлэх хугацаа дөхсөн баримт бичгийн мэдээг долоо хоног бүрийн даваа гарагт гарган, холбогдох мэргэжилтнүүдэд нь танилцуулж, гарын үсэг зуруулан баталгаажуулж байсан болно.

Явуулах баримт бичгийг хүлээн авч албан бичгийн стандарт, хавсралт, явуулах хаягийн бүрэн, зөв эсэхийг шалган, тамга, тэмдэг дарах, бүртгэж дугаарлах, дугтуйлах, хаяглах, шуудангийн салбарт хүлээлгэн өгөх ажлыг журмын дагуу хийж гүйцэтгэн ажиллаж байгаа. Тайлант хугацаанд нийт 1205 албан бичигт дугаар өгч, edoc программаар бүртгэн, холбогдох байгууллагуудад нь шилжүүлж, албан бичгийг шуудангийн салбарт хүлээлгэн өгсөн.

Жич: eDoc системээр албан бичиг илгээсэн байгууллага нь зарим хариутай бичигт “хариугүй” гэж тэмдэглэн ирүүлсэн байна. Хариугүй төлөвтэй ирсэн хариутай бичиг нь хариугүй бичигт орсон болно.